



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

“Голомт банк” ХХК-иас  
гадаадын хөрөнгийн бирж дээр гаргах  
үнэт цаасыг бүртгэх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 1.3, 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Голомт банк” ХХК-ийн гадаадын хөрөнгийн зах зээл дээр нийтэд санал болгон гаргаж буй 5 жилийн хугацаатай, 50,000,000 /тавин сая/ америк долларын үнийн дүн бүхий 250 ширхэг бондыг үнэт цаасны бүртгэлд нэмж бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т үүрэг болгосугай.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 4.1-д заасны дагуу үнэт цаасны гадаадын хөрөнгийн зах зээл дээр байршуулсан тухай болон, арилжаалагдаж буй үйл явцын талаар хагас жил тутамд Хороонд ирүүлж, тайлагнаж байхыг “Голомт банк” ХХК /Жон П.Финиган/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН